

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан



АЙМГИЙН ИТХ-ЫН “2019 ОНД ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ”, “2019 ОНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АГНАХ, БАРИХ АН АМЬТНЫ ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ” ТОГТООЛУУДЫН ХЭРЭГЖИЛТ



Ойн мэргэжлийн байгууллагуудтай өмнөх онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэлгүйгээр болон ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүйгээр мод бэлтгэх эрхийн бичиг олгож буй зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.



2020 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж байгууллага
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОУБ	Байгаль орчны улсын байцаагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
МБУ	Мод бэлтгэлийн үйлдвэр
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс



Тайланг бэлтгэсэн:

🏠 Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
С.Баасансүрэн

Аудитор
Т.Одсүрэн
Д.Чулуунцэцэг

📞 Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах утас **70362442,**
70363047, 70363040

✉ **Selenge**
@audit.gov.mn мэйл
хаягаар харилцана уу.

📍 **ХАЯГ:** Сэлэнгэ
аймгийн ЗДТГ-ын
өргөтгөлд

2020 оны 6 дугаар сар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл
Аудитын дүн

1. 2019 онд үйлдвэрийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх тухай тогтоолын хэрэгжилт хангагдаж байна уу?

1.1 Ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлж байна уу?

1.2 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн үү?

1.3 Ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг баталсан тогтоолын хэрэгжилт, орлого төвлөрүүлэлтэд үр нөлөө бүхий дотоод хяналт, шалгалт хийгдэж байна уу?

2. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилт хангагдаж байна уу?

2.1. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны дээд хязгаарыг тогтоосон тоо, хэмжээг агнуурын үйл ажиллагаанд мөрдөж байна уу?

2.2. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийн хураамжийн орлогыг холбогдох хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх?

2.3. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилтэд хяналт хийгдэж байгаа эсэх?

Илрүүлсэн зөрчил

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийх үндэслэл

Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах, ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны тоо хэмжээг батлах тухай тогтоолуудын хэрэгжилтэд аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 2019 онд үйлдвэрийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх тухай тогтоолын хэрэгжилтийг хангаж байна уу?
- 2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилтийг хангаж байна уу?

1. Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймгийн БОАЖГ, сум дундын болон сумын ойн ангийн дарга, инженер, техникийн ажилтнууд, сумдын санхүүгийн албаны дарга, татварын байцаагч, байгаль орчны улсын байцаагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудыг хамруулан шалгав.

2. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг ашиглан, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс цуглуулан дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судалгаа хийсэн,
- 2019 онд ойн сангаас бэлтгэх модны дээд хэмжээг мөрдөн ойн мэргэжлийн байгууллагуудад мод бэлтгэх эрх олгох шийдвэр, гэрээний хэрэгжилт, гарал үүсэл болон эрхийн гэрчилгээ олголт, үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, баримт материалд дүн шинжилгээ хийсэн,

- 2019 онд аймгийн агнуурын бүс нутгаас ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны тоо, хэмжээ, орлогын гүйцэтгэл, эрх олгох шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой шийдвэр баримт материалд дүн шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийлээ.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

- Төсвийн тухай хууль ,
- Ойн тухай хууль ,
- Амьтны тухай хууль,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль,
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль ,
- Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “*Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай журам*”,
- Засгийн газрын 2014 оны 307 дугаар тогтоолоор батлагдсан “*Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай журам*”,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-53 дугаар тушаалаар батлагдсан “*Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам*”,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-153 дугаар тушаалаар батлагдсан “*Гарал үүслийн гэрчилгээ олгох хяналт тавих журам*”,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/166 дугаар тушаалаар батлагдсан “*Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам*”,
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан “*Ойгоос мод бэлтгэх журам*”,
- Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “*Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам*”, “*Агнуур зохион байгуулах мэргэжлийн байгууллагын ажиллах журам*”
- Дээрх хууль, журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, холбогдох бусад хууль эрхийн актууд.

3. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Т.Одсүрэн, Д.Чулуунцэцэг нар 2020 оны 05 дугаар сарын 12-ноос 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 126 дугаар тогтоолоор Ерөө бүсийн сум дундын ойн ангийг Ерөө суманд, Хараагийн бүсийн сум дундын ойн ангийг Мандал суманд, Орхоны бүсийн сум дундын ойн ангийг Баруунбүрэн суманд, Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн ангийг Сүхбаатар суманд байршуулахаар анх байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 105 дугаар тогтоолоор Бэлчир-Сэлэнгийн бүсийн сум дундын ойн ангийг Цагааннуур суманд байршуулахаар өөрчлөлт оруулсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийг Ерөө сумын Бугант тосгонд, Хараагийн бүсийн сум дундын ойн ангийг Мандал суманд, Орхоны бүсийн сум дундын ойн ангийг Баруунбүрэн суманд, Сэлэнгэ бүсийн сум ойн ангийг Цагааннуур суманд, Бэлчир бүсийн сум дундын ойн ангийг Сүхбаатар суманд байршуулахаар зохион байгуулалтыг өөрчилсөн байна.

Хүдэр сумын ИТХ-ын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 116 дугаар тогтоолоор “Хүдэр сумын ойн анги” ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2019 онд ойгоос 97820 м³ хэрэглээний, 107970 м³ түлээний мод бэлтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 61161.8 м³ хэрэглээний, 48669.1 м³ түлээний мод бэлтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогод 680,299.9 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 767,137.6 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 112.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Сэлэнгэ аймгийн БОАЖГ нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2019 онд шинээр боловсруулж 2020 онд БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын даргаар батлуулан ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум тус бүрээр агнуурын бүс нутгийн хамт баталсан байна.

АУДИТЫН ДҮН

Бүлэг 1

2019 онд үйлдвэрийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх тухай тогтоолыг хэрэгжүүлсэн үү?

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.

1.1 Ойгоос бэлтгэх модны тоо хэмжээг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлж байна уу?

Аймгийн Засаг дарга 2019 онд ойгоос бэлтгэх модны саналыг хугацаа нь дууссан ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн боловсруулсан байна.

Сумын Засаг дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх тухай журам”-ын 2.2¹-т заасны дагуу дараа онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээний талаарх саналаа тухайн оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад хүргүүлэхээр зохицуулагдсан байдаг.

Аймгийн БОАЖГ нь 2019 онд ойгоос мод бэлтгэх төлөвлөгөөг сумдаас ирүүлсэн саналыг үндэслэн боловсруулсан боловч Баруунбүрэн, Баянгол, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Сайхан, Хушаат, Хүдэр, Шаамар сумд нь бэлтгэх модны тоо хэмжээний талаарх саналаа албан бичгээр баталгаажуулж ирүүлээгүй байна.

Ойн тухай хуулийн 32.3²-т сумын ИТХ нь ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээг ААНБ, нөхөрлөл бүрээр баталж, тогтоолоор баталгаажуулах ёстой атал Баянгол, Жавхлант, Сүхбаатар, Шаамар сум өөрийн нутаг дэвсгэрээс бэлтгэх түлээний модны хэмжээг тогтоол гаргаж баталгаажуулаагүй бол Баруунбүрэн, Сант, Хушаат сум хэрэглээний мод, түлээ бэлтгэх ААНБ, нөхөрлөл, баг бүрээр нь бус бөөн дүнгээр баталсан байна. Үүнд:

¹ Сум, дүүргийн Засаг дарга нь дараа жилд бэлтгэх модны төлөвлөлтийг дор дурдсан баримт бичигт үндэслэн гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад тухайн оны 5 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ. Үүнд: 2.2.1. сумын ойн менежментийн төлөвлөгөө, 2.2.2. ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөө, 2.2.3. иргэдийн ахуйн болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар бэлтгэх модны хэмжээний талаарх багийн Засаг даргын санал

² Сумын ИТХ нь дараа жилд бэлтгэх модны хэмжээг ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөө болон иргэдийн хэрэгцээг үндэслэн дараах байдлаар тогтооно. Үүнд: үйлдвэрлэлийн ашиглалт явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн огтлолтыг байгууллага бүрээр, ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулах эрх бүхий аж ахуйн нэгжид арчилгаа, цэвэрлэгээний огтлолтыг байгууллага бүрээр, ойн нөөц бүхий аймаг, сумын иргэдийн ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын огтлолтыг баг бүрээр батална.

- Баруунбүрэн сумын ИТХ нь зэргэлдээх Орхон, Орхонтуул сумын иргэдийн бэлтгэх модны хэмжээг бөөн дүнгээр,
- Сант сумын ИТХ нь иргэдийн бэлтгэх хэрэглээний 330 м3, түлээний 2780 м3 модны хэмжээг бөөн дүнгээр,
- Хушаат сумын ИТХ аж ахуйн нэгж, нөхөрлөл, иргэдийн бэлтгэх хэрэглээний 1600 м3, түлээний 2100 м3 модны хэмжээг зөвхөн модны төрөл, бэлтгэх байршлаар баталсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх тухай журам”-ын 2.3-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд заасан жилд бэлтгэх модны боломжит хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр, сумдын саналыг үндэслэн өөрийн аймгийн ойн сангаас дараа жилд бэлтгэх модны талаарх саналаа Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ.” гэж заасан байдаг.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2019 онд бэлтгэх модны саналыг аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 1/311 дүгээр албан бичгээр БОАЖЯ-нд хүргүүлсэн боловч уг саналыг ашиглалтын хугацаа дууссан аймаг болон Баруунбүрэн, Зүүнбүрэн, Сант, Хушаат сумдын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн боловсруулсан байна.

Аймаг, сумдын дараа жил бэлтгэх модны дээд хэмжээг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хуваарийг үндэслэн аймгийн ИТХ нь тухайн оны 10 дугаар сарын 10-ны дотор, сумын ИТХ нь 12 дугаар сарын 10-ны дотор багтаан баталж байхаар зохицуулагдсан байдаг.

Аймгийн Засаг даргын хүргүүлсэн саналыг үндэслэн БОАЖС-ын 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/299 дүгээр тушаалаар 2019 онд бэлтгэх хэрэглээний модны дээд хязгаарыг 97820 м3 / Үүнээс улсын тусгай хамгаалалттай газрын ойгоос бэлтгэх модны дээд хязгаар 1000 м3 / , түлээний модны дээд хязгаарыг 107970 м3 нийт 205,790 м3-ээр тогтоож, баталгаажуулсан байна.

Харин сумдын ИТХ нь дараа онд мэргэжлийн байгууллагаар бэлтгүүлэх модны хуваарийг хуульд заасан хугацаанд нь бус 2018 оны 12 дугаар сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд буюу 1-2 сарын дараа баталсан байна.

БОАЖС-ын хянаж ирүүлсэн дээд хязгаарт үндэслэн баталсан аймгийн ИТХ-ын 2018 оны 86 дугаар тогтоолд 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 77, 12 дугаар сарын 03-ны өдрийн 127 дугаар тогтоолуудаар нэмэлт өөрчлөлт оруулснаар 2019 онд ойгоос бэлтгэх модны хэмжээг 205790 м3 байхаар буюу БОАЖС-аас хянагдаж ирсэн хэмжээнд багтаан баталсан байна.

2019 онд сумдаас ирүүлсэн мод бэлтгэх санал, аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан модны хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 /м3-ээр/

№	Сумын нэр	Х/н	Сумдаас ирүүлсэн санал			Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан		
			Хэрэглээ	Түлээ	Дүн	Хэрэглээ	Түлээ	Дүн
1	Алтанбулаг	м3	5,891	9,487	15,378	2,450	9,300	11,750
2	Баруунбүрэн	м3	4,950	4,500	9,450	2,850	4,250	7,100
3	Баянгол	м3	500	3,500	4,000	-	3,500	3,500
4	Ерөө	м3	53,729	5,500	59,229	26,880	5,500	32,380
5	Жавхлант	м3	300	1,000	1,300	400	1,000	1,400
6	Зүүнбүрэн	м3	1,200	2,200	3,400	1,150	2,100	3,250
7	Мандал	м3	34,624	25,477	60,101	29,090	18,250	47,340
8	Орхон	м3	200	2,500	2,700	1,400	2,500	3,900
9	Орхонтуул	м3	500	1,500	2,000	-	1,500	1,500
10	Сайхан	м3	1,600	3,500	5,100	400	3,500	3,900
11	Сант	м3	750	3,400	4,150	750	3,600	4,350
12	Сүхбаатар	м3	1,000	28,000	29,000	1,100	28,000	29,100
13	Түшиг	м3	7,400	4,500	11,900	6,600	4,500	11,100
14	Хушаат	м3	1,900	2,600	4,500	1,600	2,100	3,700
15	Хүдэр	м3	18,374	16,933	35,307	14,450	12,300	26,750
16	Цагааннуур	м3	5,842	3,648	9,490	6,800	3,620	10,420
17	Шаамар	м3	2,000	2,450	4,450	1,900	2,450	4,350
	Дүн		140,760	120,695	261,455	97,820	107,970	205,790

Дээрхээс үзэхэд 2019 онд сумд 261455 м3 мод ойгоос бэлтгэх саналыг аймгийн БОАЖГ-т хүргүүлсэн боловч аймгийн ИТХ-аар хэрэглээний мод 97820 м3, түлээний 107970 м3, нийт 205790 м3 мод бэлтгэхээр хянаж, БОАЖС-аар батлуулсан байна.

Сумдаас ирүүлсэн саналыг аймгийн БОАЖГ нь өмнөх оны гүйцэтгэл, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлтгэх боломжтой нөөцтэй уялдуулан 55665 м3 буюу 27 хувиар бууруулсан байна.

БОАЖС-ын хянаж, аймгийн ИТХ-ын тогтоолоор баталж, хуваарилсан 2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг Баянгол, Жавхлант, Сүхбаатар, Шаамар сумын ИТХ нь ойн мэргэжлийн ААН, нөхөрлөлүүдэд хуваарилж, тогтоолоор баталгаажуулаагүй бол бусад 14 сумын ИТХ нь модны хэмжээг бууруулж баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2 /м3-ээр/

№	Сумдын нэр	х/н	Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан			Сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан		
			Хэрэглээ	Түлээ	дүн	Хэрэглээ	Түлээ	дүн
1	Алтанбулаг	м3	2,450	9,300	11,750	1,250	15,800	17,050
2	Баруунбүрэн	м3	2,850	4,250	7,100	1,350	4,360	5,710
3	Баянгол	м3	-	3,500	3,500	Тогтоол гаргаагүй		
4	Ерөө	м3	26,880	5,500	32,380	26,880	5,500	32,380
5	Жавхлант	м3	400	1,000	1,400	Тогтоол гаргаагүй		

6	Зүүнбүрэн	м3	1,150	2,100	3,250	150	150	300
7	Мандал	м3	29,090	18,250	47,340	26,740	18,250	44,990
8	Орхон	м3	1,400	2,500	3,900	-	1,500	1,500
9	Орхонтуул	м3	-	1,500	1,500	-	1,500	1,500
10	Сайхан	м3	400	3,500	3,900	100	3,500	3,600
11	Сант	м3	750	3,600	4,350			
12	Сүхбаатар	м3	1,100	28,000	29,100	Тогтоол гаргаагүй		
13	Түшиг	м3	7,600	4,500	12,100	8100	5,400	13,500
14	Хушаат	м3	1,600	2,100	3,700	1,600	2,100	3,700
15	Хүдэр	м3	14,450	12,300	26,750	11,250	12,300	23,550
16	Цагааннуур	м3	5,800	3,620	10,420	5,800	3,620	9,420
17	Шаамар	м3	1,900	2,450	4,350	Тогтоол гаргаагүй		
	Дүн		97,820	107,970	205,790	83,970	78,260	162,230

Аймгийн ИТХ-аар баталсан модны дээд хязгаарыг Түшиг сум 1400 м3 /хэрэглээ 500 м3, түлээ 900 м3/ -ээр нэмэгдүүлэн баталсан бол бусад сумд аймгийн ИТХ-аар баталсан хэмжээнээс нийт 43560 м3-ээр бууруулж баталсан байна.

Дээрхээс дүгнэхэд ойгоос бэлтгэх модны төлөвлөгөөнд сумдын саналыг бүрэн тусгаагүйгээс аймгийн ИТХ-аар батлагдсан хуваарь, сумдаас ирүүлсэн саналын хооронд ихээхэн зөрүү гарах, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөний дагуу мод бэлтгэлийн ажил хийгдэхгүй байх, сумд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан хуваарийг дагаж мөрдөхгүй байх, тогтоосон хязгаараас хэтрүүлэх зөрчил оршоор байна.

1.2 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн үү ?

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 7.8 хувиар тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 23.8.7-д ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг сумын төсвийн татварын орлогын бүрэлдэхүүн байхаар хуульчилсан байдаг.

Аймгийн Засаг даргаас БОАЖЯ-д хүргүүлсэн саналд 2019 онд аймгийн хэмжээнд ойгоос бэлтгэх хэрэглээний модны хэмжээг 97820 м3, түлээний модны хэмжээг 107970 м3-ээр тооцож, Засгийн газрын 2017 оны 307 дугаар тушаалаар баталсан “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын дагуу дээрх орлогыг 680,299.3 мянган төгрөг байхаар тооцож, төлөвлөсөн байна.

Аймгийн БОАЖГ-аас 2019 онд бэлтгэх модны дээд хэмжээг тогтоосон БОАЖС-ын тушаал, аймгийн ИТХ-ын 2019 онд “Ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай” тогтоолыг үндэслэн дээрх журмын дагуу 1м3 модонд ногдох төлбөрийн хэмжээгээр орлогыг тооцож аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

Аймгийн БОАЖГ-ын боловсруулсан орлогын төлөвлөгөөний саналыг аймгийн ИТХ-аар сумдад хуваарилан баталсан төлбөрийн орлогын төлөвлөгөөтэй харьцуулсныг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 /мянган төгрөгөөр/

№	Ойн анги	Сумдын нэр	Орлогын төлөвлөлт		Зөрүү
			БОАЖГ-ын төлөвлөгөөний санал	Аймгийн ИТХ-аар батлагдсан орлогын хуваарь	
1	Бэлчир бүсийн ойн анги	Алтанбулаг	20,653.3	37,485.8	16,832.5
2		Шаамар	16,152.5	-	-16,152.5
3		Сүхбаатар	32,490.0	40,890.0	8,400.0
4	Ерөө бүсийн ойн анги	Ерөө	198,172.0	248,680.5	50,508.5
5	Хараа бүсийн ойн анги	Мандал	195,909.7	195,036.1	-873.6
6		Баянгол	2,565.0	2,565.0	-
7	Сэлэнгэ бүсийн ойн анги	Цагааннуур	40,246.8	40,546.8	300.0
8		Зүүнбүрэн	2,850.0	11,250.0	8,400.0
9		Түшиг	36,761.6	50,553.0	13,791.4
10	Орхон бүсийн ойн анги	Орхон	2,850.0	2,850.0	-
11		Сайхан	4,275.0	-	-4,275.0
12		Орхонтуул	1,710.0	1,710.0	-
13		Баруунбүрэн	14,206.1	12,210.9	-1,995.2
14		Сант	7,381.5	7,495.5	114.0
15		Хушаат	8,011.2	15,000.0	6,988.8
16	Хүдэр сумын ойн анги	Хүдэр	94,126.6	164,875.7	70,749.1
17		Жавхлант	1,938.0	600.0	-1,338.0
		Дүн	680,299.3	831,749.3	151,450.0

Дээрхээс үзэхэд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн орлого бүртгэлийн мэргэжилтэн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр Алтанбулаг, Сүхбаатар, Ерөө, Зүүнбүрэн, Түшиг, Хушаат, Хүдэр сумдад нийт 151,450.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол аймгийн СТСХ, БОАЖГ-ын мэргэжилтнүүд ойн нөөцгүй Сүхбаатар, Шаамар, Сайхан, Орхон, Орхонтуул, Жавхлант, Зүүнбүрэн сумдад орлого төлөвлөн, аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

Сум дундын болон сумын ойн анги нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7³-д заасны дагуу ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сумын ИТХ-аас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргаж ажиллахаар зохицуулсан байдаг.

³ Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сумын ИТХ-аас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2019 онд ойгоос хэрэглээний мод 97820 м3, түлээний мод 107970 м3 бэлтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр хэрэглээний мод 61161.8 м3 буюу 62.5 хувийг, түлээний мод 48669.1 м3 буюу 45.07 хувийг тус тус бэлтгэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 /м3-ээр/

№	Ойн анги	Сумдын нэр	Хэмжих нэгж	2019 онд бэлтгэх модны тоо хэмжээ						Зөрүү
				Төлөвлөгөө			Гүйцэтгэл			
				Хэрэглээ	Түлээ	Дүн	Хэрэглээ	Түлээ	Дүн	
1	Бэлчир бүсийн ойн анги	Алтанбулаг	м3	2,450.0	9,300.0	11,750.0	1,372.7	5,662.0	7,034.7	(4,715.3)
2		Шаамар	м3	1,900.0	2,450.0	4,350.0	1,400.0	816.0	2,216.0	(2,134.0)
3		Сүхбаатар	м3	1,100.0	28,000.0	29,100.0	99.0	2,023.0	2,122.0	(26,978.0)
4	Ерөө бүсийн ойн анги	Ерөө	м3	26,880.0	5,500.0	32,380.0	20,932.0	6,446.0	27,378.0	(5,002.0)
5	Хараа бүсийн ойн анги	Мандал	м3	29,090.0	18,250.0	47,340.0	14,866.0	7,850.0	22,716.0	(24,624.0)
6		Баянгол	м3	-	3,500.0	3,500.0		652.0	652.0	(2,848.0)
7	Сэлэнгэ бүсийн ойн анги	Цагааннуур	м3	5,800.0	3,620.0	10,420.0	4,604.1	2,631.1	7,235.2	(3,184.8)
8		Зүүнбүрэн	м3	1,150.0	2,100.0	3,250.0	155.0	86.0	241.0	(3,009.0)
9		Түшиг	м3	7,600.0	4,500.0	11,100.0	5,466.0	2,770.0	8,236.0	(2,864.0)
10	Орхон бүсийн ойн анги	Орхон	м3	1,400.0	2,500.0	3,900.0	214.0	966.0	1,180.0	(2,720.0)
11		Сайхан	м3	400.0	3,500.0	3,900.0	268.0	746.0	1,014.0	(2,886.0)
12		Орхонтуул	м3		1,500.0	1,500.0		50.0	50.0	(1,450.0)
13		Баруунбүрэн	м3	2,850.0	4,250.0	7,100.0	1,039.1	2,556.0	3,595.1	(3,504.9)
14		Сант	м3	750.0	3,600.0	4,350.0	443.0	3,878.0	4,321.0	(29.0)
15		Хушаат	м3	1,600.0	2,100.0	3,700.0	58.0	897.0	955.0	(2,745.0)
16	Хүдэр сумын ойн анги	Хүдэр	м3	14,450.0	12,300.0	26,750.0	10,245.0	10,640.0	20,885.0	(5,865.0)
17		Жавхлант	м3	400.0	1,000.0	1,400.0			-	-
		Дүн		97,820.0	107,970.0	205,790.0	61,161.9	48,669.1	109,831.0	(94,559.0)

Дээрхээс үзэхэд сумдын ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх тоо хэмжээг үндэслэлгүй нэмэгдүүлэн төлөвлөснөөс гүйцэтгэлээр бүх сумд төлөвлөгөөг тасалсан байна. Тухайлбал, аймгийн ИТХ-ын тогтоолоор Сүхбаатар суманд хэрэглээний 1100 м3, түлээний 28000 м3 мод бэлтгэхээр хуваарилагдсан боловч гүйцэтгэлээр хэрэглээний 99 м3, түлээний 2023 м3 мод /Алтанбулаг сумын ИТХ-аас тус суманд бэлтгэх хэрэглээний 1250 м3, түлээний 9300 м3 мод бэлтгэхээр баталсан. / бэлтгэсэн байна.

Мандал сум хэрэглээний мод 7850 м3, түлээний мод 22716 м3-ээр дутуу буюу нийт бэлтгэх модны 52 хувийг бэлтгээгүй нь цаг уур эрс дулаарч цас хайлсны улмаас зам харгуй хаагдаж, мод бэлтгэлийн ажил удааширч төлөвлөгөөний дагуу хийгдээгүйгээс шалтгаалсан гэсэн тайлбарыг өгсөн.

Энэ нь аймгийн ИТХ-ын “2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай” тогтоолын хэрэгжилт хангагдахгүй байх, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2019 онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогод 831,749.3 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 767,137.6 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 92.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5 /мянган төгрөгөөр/

№	Ойн анги	Сумдын нэр	Тайлант он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бэлчир бүсийн ойн анги	Алтанбулаг	37,485.8	27,468.2	(10,017.6)	73.3
2		Шаамар	-	11.2	11.2	-
3		Сүхбаатар	40,890.0	22.0	(40,868.0)	0.1
4	Ерөө бүсийн ойн анги	Ерөө	248,680.5	269,551.6	20,871.1	108.4
5	Хараа бүсийн ойн анги	Мандал	195,036.1	130,543.3	(64,492.8)	66.9
6		Баянгол	2,565.0	6,392.6	3,827.6	249.2
7	Сэлэнгэ бүсийн ойн анги	Цагааннуур	40,546.8	62,062.0	21,515.2	153.1
8		Зүүнбүрэн	11,250.0	924.7	(10,325.3)	8.2
9		Түшиг	50,553.0	46,565.6	(3,987.4)	92.1
10	Орхон бүсийн ойн анги	Орхон	2,850.0	-	-	-
11		Сайхан	-	-	-	-
12		Орхонтуул	1,710.0	-	-	-
13		Баруунбүрэн	12,210.9	20,230.1	8,019.2	165.7
14		Сант	7,495.5	10,997.3	3,501.8	146.7
15		Хушаат	15,000.0	1,418.7	(13,581.3)	9.5
16	Хүдэр сумын ойн анги	Хүдэр	164,875.7	190,558.2	25,682.5	115.6
17		Жавхлант	600.0	392.1	(207.9)	65.4
		Дүн	831,749.3	767,137.6	(64,611.7)	92.2

Дээрхээс үзэхэд Бэлчир бүсийн сум дундын ойн анги орлогын төлөвлөгөөг 50,874.4 мянган төгрөг буюу 64.9 хувиар, Хараа бүсийн сум дундын ойн анги 60,665.2 мянган төгрөг буюу 30.7 хувиар, Орхон бүсийн сум дундын ойн анги нь 2,060.3 мянган төгрөг буюу 15.4 хувиар тасалдуулсан бол Ерөө сумын ойн анги 20,871.1 мянган төгрөг буюу 8.4 хувиар, Хүдэр сумын ойн анги ОНӨААТҮГ 25,474.6 мянган төгрөг буюу 15.4 хувиар давуулж биелүүлсэн байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42.1, 42.5-д тэмдэгтийн хураамжийг хуульд заасан үйлчилгээ үзүүлж байгаа эрх бүхий байгууллагад бэлэн

болон бэлэн бус хэлбэрээр ногдуулж төвлөрүүлэн хуулийн биелэлтэд татварын алба хяналт тавихаар зохицуулсан бол Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх журам”-ын 3.2⁴, 3.3⁵-т ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх талбай тусгаарлалтын мөнгөн үнэлгээ хийх, мод бэлтгэх эрхийн бичиг олгох, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэхээр заасан байна.

Гэтэл зарим ойн анги, байгаль хамгаалагчид улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тооцож, төвлөрүүлээгүй, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүйгээр эрхийн бичиг олгож, авлага үүсгэдэг зэрэг зөрчлийг гаргасан байна. Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамжийг дутуу тооцсон, орлого дутуу төвлөрүүлсэн 12,899.1 мянган төгрөгийн :

- Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги нь улсын тэмдэгтийн хураамжийг 227.4 мянган төгрөгөөр дутуу тооцсон, 177.3 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч, зарцуулсан,
- Ерөө сум 6,225.0 мянган төгрөгийн, Хүдэр сум 6,089.1 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг тооцоогүй,
- Улсын тэмдэгтийн хураамжийг Баруунбүрэн сум 81.6 мянган төгрөгөөр, Баянгол сум 18.2 мянган төгрөгөөр, Хушаат сум 81.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

2. Хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүйгээр эрхийн бичиг олгосноос 40,735.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Үүнд:

- Ерөө бүсийн сум дундын ойн ангид 2018 онд үүссэн Номин-Од ХХК 16,018.7 мянган төгрөг, Цант-Ажнай ХХК-иас 3,307.4 мянган төгрөг, Ар-Санжит ХХК-иас 2,593.9 мянган төгрөг зэрэг нийт 21,920.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй,
- Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги нь 2019 онд Түшиг суманд мод бэлтгэсэн Мойлт нуга ХХК-иас 10,894.6 мянган төгрөг, Шинэбадрах ХХК-иас 6,678.3 мянган төгрөг, Хараа бүсийн сум дундын ойн анги нь Мандал суманд мод бэлтгэсэн Тайлжийн нуруу ХХК-иас 1,242.3 мянган төгрөгийн зэрэг нийт 18,815.2 мянган төгрөгийн төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

1.3 Ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг баталсан тогтоолын хэрэгжилт, орлого төвлөрүүлэлтэд үр нөлөө бүхий дотоод хяналт, шалгалт хийгдэж байна уу?

⁴ Ойгоос мод бэлтгэх эрх авсан нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага мод бэлтгэх талбайг Ойн ангиар тусгаарлуулж, мөнгөн үнэлгээ хийлгэсэн байна.

⁵ Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, “Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг”-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна.

Ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг баталсан тогтоолын хэрэгжилт, орлого төвлөрүүлэлтэд үр нөлөө бүхий дотоод хяналт, шалгалт хийдэггүй, аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлдэггүйгээс зөрчил, дутагдал давтагдан гарч байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 86 дугаар тогтоолын хэрэгжилтэд сумын болон сум дундын ойн ангийн дарга болон аймгийн БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар, сумдын ИТХТ, Засаг дарга нарыг хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 103 ААН, 78 нөхөрлөл үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эдгээртэй гэрээ байгуулж, хэрэгжилтийг тооцсон байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7

№	Ойн ангийн нэр	Ойн мэргэжлийн байгууллагын бүртгэлтэй ААН, нөхөрлөл								Сумын ИТХ -аар гэрээг дүгнэж, ажлын тайланг хэлэлцсэн эсэх
		ААН тоо	Гэрээ			Нөхөрлөл тоо	Гэрээ			
			Байгуулсан	Байгуулаагүй	Дүгнэсэн		Байгуулсан	Байгуулаагүй	Дүгнэсэн	
1	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	6	6	-	-	9	9	-	-	Үгүй
2	Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги	8	8	-	8	-	-	-	-	Тийм
3	Ерөө бүсийн сум дундын ойн анги	31	28	3	28	25	22	3	-	Үгүй
4	Хүдэр сумын ойн анги	32	32	-	32	15	15	0	15	Тийм
5	Хараа бүсийн сум дундын ойн анги	23	21	2	21	29	28	1	23	Тийм
6	Орхон бүсийн сум дундын ойн анги	3	3	-	-	-	-	-	-	Үгүй
Бүгд		103	98	5	89	78	74	4	38	

Дээрхээс үзэхэд Ерөө бүсийн сум дундын ойн анги нь 3 ААН, 3 нөхөрлөл, Хараа бүсийн сум дундын ойн анги 2 ААН, 1 нөхөрлөлтэй гэрээ байгуулаагүй бол аймгийн дүнгээр 119 ААН, нөхөрлөлийн гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна. Үүнд:

- *Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг Төгөлдөр хангай ХХК, Ерөөлт хангай ХХК, Бишрэлт баян хангай ХХК болон Баянгол, Ариун гацуур, Гурван гол нөхөрлөлүүд ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй тул гэрээ байгуулаагүй,*

- Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг Өнө манлай ХХК, Хургалаг нөхөрлөл ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй, Цогт сүндэр ХХК-ийн үйл ажиллагаа хангалтгүй гэсэн үндэслэлээр Хараа бүсийн сум дундын Ойн анги тус тус гэрээ байгуулаагүй,
- Аймгийн дүнгээр нийт 89 ААН, 38 нөхөрлөлтэй байгуулсан гэрээг дүгнэсэн боловч Бэлчир, Ерөө, Орхон бүсийн сумдууд сумын ИТХ-аар хэлэлцэж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

БОАЖС-ын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх журам”-ын 9.1-д “сумын Засаг даргын томилсон албан тушаалтан ойгоос мод бэлтгэсэн ажлын тайланг гаргаж, Ойн анги хянаж нэгтгэн тухайн оны 12 сарын 01-ний дотор аймгийн БОАЖГ-т хүргүүлнэ.” гэж заасан байна.

Аудитын явцад 2019 онд аймгийн хэмжээгээр ойгоос бэлтгэсэн модны тоо хэмжээний судалгаа хийж, аймгийн БОАЖГ-ын гаргаж, мэдээлсэн ойгоос бэлтгэсэн модны мэдээ тайлантай тулган баталгаажуулахад дараах зөрүү гарлаа. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8

№	Мод бэлтгэл	Гүйцэтгэл			
		Хэрэглээ / м3 /	Түлээ /м3/	Бүгд дүн	Мөнгөн дүн /мян.төгрөг/
1	Байгаль орчны мэдээгээр	65265.0	47958.0	113223.0	769,770.7
2	Аудитын тулган баталгаажуулалтаар	61161	48669.0	109830.9	767,137.6
	Зөрүү	(4,104)	711.1	(3,392.1)	(2,633.1)

Хүснэгтээс харахад БОАЖГ-ын гаргасан ойгоос бэлтгэсэн мод бэлтгэлийн мэдээ тайлан аудитаар тулган баталгаажуулсан дүнгээс хэрэглээ 4104 м3-ээр илүү, түлээ-711 м3-ээр дутуу, орлогын гүйцэтгэл 2,633. мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн гэж зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь ойн ангиудын мэдээ тайланг батлагдсан маягт аргачлалын дагуу хугацаанд нь албан ёсоор авч нэгтгэдэггүй, үнэн зөвд нь хяналт тавьж баталгаажуулдаггүй зэргээс голлон шалтгаалсан гэж үзэж байна.

Аудитын дүнгээс харахад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх үйл ажиллагааны дээд хэмжээг тогтоосон аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олголт, хууль тогтоомжоор төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлогын гүйцэтгэлд аймгийн холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас үр нөлөө бүхий дотоод хяналт шалгалт хийдэггүй болох нь харагдаж байна.

Мөн аймгийн Төрийн аудитын газраас 2018 онд хийж гүйцэтгэсэн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс бэлтгэх мод

түлээний хэмжээг үндэслэлгүй төлөвлөдөг, орлого дутуу төвлөрүүлдэг, мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүйгээр эрхийн бичиг олгож авлага үүсгэдэг, мэдээ тайланг зөрүүтэй гаргаж, мэдээлдэг зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Бүлэг 2

Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилт хангагдаж байна уу?

Аймгийн ИТХ-аар баталсан ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээ хэтрээгүй боловч орлогын төлөвлөгөө 75.8 хувиар тасарсан байна.

2.1 Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны дээд хязгаарыг тогтоосон тоо, хэмжээг агнуурын үйл ажиллагаанд мөрдөж байна уу?

Ахуйн зориулалтаар агнасан, барьсан амьтны тоо хэмжээ нь агнах барихаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байна.

Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2-т “Агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуй, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг, батлах хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасны дагуу ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2019 онд шинэчлэн боловсруулж, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраар батлуулсан байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1-д “Батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх” гэж заасны дагуу ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тооцож, санал боловсруулан хуулийн хугацаанд БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.

Дээрх саналыг үндэслэн БОАЖС-ын 2018 оны А/541 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар “Сэлэнгэ аймагт 2019 онд ахуйн зориулалтаар бор гөрөөс 30, зэрлэг гахай 40 толгойг агнах, загас 1000 ширхэг барихаар” баталж, хуваарилсан байна.

Амьтны тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2⁶-т заасны дагуу аймгийн БОАЖГ нь ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны төрөл, тоо

⁶ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно.

хэмжээг агнуурын бүс нутаг бүхий сумдад хуваарилах саналыг боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Уг саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 2019 онд ахуйн зориулалтаар агнах барих ан амьтны тоо хэмжээг бор гөрөөс 30, зэрлэг гахай 40-ийг агнахаар, загас 1000 ширхгийг барихаар тогтоож, агнуурын бүс нутаг бүхий сумдад хуваарилсан байна.

Агнуурын нөөц бүхий сумууд нь ахуйн зориулалтаар агнах барих ан амьтны тоо хэмжээг хэтрүүлээгүй бөгөөд зохистой ашиглалт болон агнах хугацааг баримтлан бор гөрөөс 17, зэрлэг гахай 25 толгойг агнаж, загас 337 ширхгийг барьсан байна.

2.2 Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийн хураамжийн орлогыг холбогдох хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн үү ?

Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийн хураамжийн орлогыг үндэслэлгүйгээр төлөвлөснөөс орлого 75.8 хувиар тасарсан байна.

Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо болон Засгийн газрын 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн 2019 онд төсөвт төвлөрүүлэх ан агнуурын нөөцийн орлогыг төлөвлөх ёстой атал урьд оны орлогын гүйцэтгэлд тулгуурлан төсвийг батлуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7 /мянган төгрөгөөр/

№	Сумдын нэр	Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан агнах барих ан амьтны тоо ширхэг, төсөвт төвлөрүүлэх орлогын дүн						2019 онд батлагдсан төсөв	Зөрүү	
		Бор гөрөөс		Зэрлэг гахай		Загас				Дүн
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн			
1	Алтанбулаг	2	132.0	4	560.0	-	-	692.0	5224.0	4532.0
2	Баруунбүрэн	2	132.0	2	280.0	-	-	412.0	1244.0	832.0
3	Баянгол	2	132.0	1	140.0	100	100.0	372.0	272.0	-100.0
4	Ерөө	4	264.0	8	1120.0	50	50.0	1434.0	2282.0	848.0
5	Жавхланта	1	66.0	-	-	-	-	66.0	-	-66.0
6	Зүүнбүрэн	1	66.0	-	-	100	100.0	166.0	132.0	-34.0
7	Мандал	4	264.0	4	560.0	50	50.0	874.0	1516.0	642.0
8	Орхон	1	66.0	-	-	100	100.0	166.0	700.0	534.0
9	Орхонтуул	2	132.0	-	-	100	100.0	232.0	132.0	-100.0
10	Сайхан	-	-	-	-	50	50.0	50.0	-	-50.0
11	Сант	1	66.0	2	280.0	50	50.0	396.0	618.0	222.0

12	Сүхбаатар	-	-	-	-	100	100.0	100.0	-	-100.0
13	Тушиг	3	198.0	6	840.0	50	50.0	1088.0	1590.0	502.0
14	Хушаат	2	132.0	3	420.0	100	100.0	652.0	2618.0	1966.0
15	Хүдэр	2	132.0	6	840.0	50	50.0	1022.0	1730.0	708.0
16	Цагааннуур	2	132.0	4	560.0	50	50.0	742.0	1384.0	642.0
17	Шаамар	1	66.0	-	-	50	50.0	116.0	-	116.0
	Дүн	30	1980.0	40	5600.0	1000	1000.0	8580.0	19442.0	10862.0

Дээрхээс үзэхэд амьтны экологи-эдийн засгийн үнэлгээгээр 2019 онд бор гөрөөс 30, зэрлэг гахай 40 толгойг агнахад 7,580.0 мянган төгрөг, 1000 ширхэг загас барихад 1,000.0 мянган төгрөг зэрэг нийт 8,580.0 мянган төгрөгийн ан агнуурын нөөцийн орлого бүрдэхээр тооцоологдож байна. Гэтэл ан агнуурын нөөцийн орлогыг урьд оны гүйцэтгэлд үндэслэн 10,862.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 19,442.0 мянган төгрөгийн орлогыг төлөвлөгөөг баталсан байна.

Аудитын явцад ахуйн зориулалтаар агнасан, барьсан амьтны зөвшөөрлийн хуудасны тооцоог шалгаж, ан агнуурын нөөцийн орлогын дансанд төвлөрүүлсэн орлогын дүнтэй тулган баталгаажууллаа. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8 /мянган төгрөг/

№	Сумын нэр	2019 онд ахуйн зориулалтаар агнасан, барьсан амьтны нэр төрөл, тоо ширхэг, зөвшөөрлийн хураамж дүн						Хураамжийн орлогын дүн		Төлөгд өөгүй дүн
		Бор гөрөөс		Зэрлэг гахай		Загас		Төлөх ёстой	Төлсөн	
		тоо	Мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн			
1	Алтанбулаг	1	66.0	1	140.0	0	0.0	206.0	206.0	
2	Баруунбүрэн	2	132.0	2	280.0	0	0.0	412.0	412.0	
3	Баянгол	0	0.0	1	140.0	50	50.0	190.0	190.0	
4	Ерөө	4	264.0	4	560.0	50	50.0	874.0	874.0	
5	Жавхлант	0	0.0	0	0.0	0	0.0	0.0	0.0	
6	Зүүнбүрэн	0	0.0	0	0.0	20	20.0	20.0	20.0	
7	Мандал	2	132.0	3	420.0	37	37.0	589.0	589.0	
8	Орхон	0	0.0	0	0.0	0	0.0	0.0	0.0	
9	Орхонтуул	0	0.0	0	0.0	0	0.0	0.0	0.0	
10	Сайхан	0	0.0	0	0.0	0	0.0	0.0	0.0	
11	Сант	1	66.0	2	320.0	30	30.0	416.0	416.0	
12	Сүхбаатар	0	0.0	0	0.0	20	20.0	20.0	20.0	
13	Түшиг	3	198.0	6	840.0	40	40.0	1078.0	1078.0	
14	Хушаат	2	132.0	3	420.0	40	40.0	592.0	452.0	(140.0)
15	Хүдэр	2	132.0	3	420.0	50	50.0	602.0	462.0	(140.0)
16	Цагааннуур	0	0.0	0	0.0	0	0.0	0.0	0.0	
17	Шаамар	0	0.0	0	0.0	0	0.0	0.0	0.0	
	Дүн	17	1122.0	25	3540.0	337	337.0	4999.0	4719.0	(280.0)

Дээрхээс үзэхэд Хушаат, Хүдэр сумдын байгаль хамгаалагч нар нь ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны зөвшөөрлийн хураамжийн 280.0 мянган төгрөгийг төлөөгүй 2 иргэнд зэрлэг гахай агнах зөвшөөрөл олгосон байна. Энэ нь Амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх “*Амьтан агнах, барих төлбөр, зөвшөөрлийн хураамж төлсөн байх.*” гэсэн заалтын зөрчсөн байна.

Тайлант онд аймгийн хэмжээнд 17 бор гөрөөс, 25 зэрлэг гахай агнаж, 337 ширхэг загас барьж 4,719.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 75.8 хувь буюу 14,723.0 мянган төгрөгөөр тасалсан байна.

Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийг олгохдоо улсын тэмдэгтийн хураамжийн орлогын орон нутгийн орлогод огт төлүүлээгүй байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10

№	Сумын нэр	Агнасан, барьсан амьтны тоо, төлөх ёстой улсын тэмдэгтийн хураамжийн мөнгөн дүн						Улсын тэмдэгтийн хураамжийн нийт дүн
		Бор гөрөөс	Мөнгөн дүн	Зэрлэг гахай	Мөнгөн дүн	Загас	Мөнгөн дүн	
1	Алтанбулаг	1	13.2	1	28.0	-	-	41.2
2	Баруунбүрэн	2	26.4	2	56.0	-	-	82.4
3	Баянгол	-	-	1	28	50	40.0	68.0
4	Ерөө	4	52.8	4	112.0	50	40.0	204.8
5	Зүүнбүрэн	-	-	-	-	20	16.0	16.0
6	Мандал	2	26.4	3	84.0	37	32.0	142.4
7	Сант	1	13.2	2	56.0	30	24.0	93.2
8	Сүхбаатар	-	-	-	-	20	16.0	16.0
9	Түшиг	3	39.6	6	168.0	40	32.0	239.6
10	Хушаат	2	26.4	3	84.0	40	32.0	142.4
11	Хүдэр	2	26.4	3	84.0	50	40.0	150.4
	Дүн	17	224.4	25	700.0	337	272.0	1196.4

Ахуйн зориулалтаар агнасан, барьсан ан амьтны зөвшөөрөл олгосон дээрх 11 сумын байгаль хамгаалагчид нийт 1,196.4 мянган төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна. Энэ нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.31 дэх “*Ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийг нэг удаагийн эрхийн бичигт 8000-10000 төгрөг*”, 21.1.33 дахь “*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17.1.1-17.1.4-т заасан ан амьтныг агнах, барих зөвшөөрлийн хураамжийг тухайн ан амьтны экологи - эдийн засгийн үнэлгээний 2-4 хувиар тооцно.*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.3 Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилтэд хяналт хийгдэж байгаа эсэх?

Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилтэд хэсэгчилсэн байдлаар хяналт шалгалт хийгдсэн байна.

Ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны зөвшөөрлийн эрхийн бичгийг БОАЖЯ-аас аймгийн БОАЖГ нь авч сумдын байгаль хамгаалагч нарт олгож байгаа бөгөөд уг эрхийн бичгийн орлого нь сумдын төрийн сангийн орон нутгийн орлогын “Ан агнуурын нөөцийн орлого”-д төвлөрч байгаа гэх үндэслэлээр ан агнах, барих зөвшөөрлийн эрхийн бичгийн үнэт цаасны тооцоог бодоогүй байна.

Ан амьтныг агнах, барих эрхийн бичгийн эхний болон эцсийн үлдэгдэл хөдлөл өөрчлөлт, түүнээс төвлөрүүлэх төсвийн орлогын гүйцэтгэлд сумдын Санхүүгийн албанаас хяналт тавиагүйгээс сумын байгаль хамгаалагчид их хэмжээний үнэт цаасны үлдэгдэлтэй байхад эрхийн бичгийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй, хүчингүй болсон эрхийн бичгийг устгалд оруулаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нар, БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газарт тус тус даалгасан байна.

Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Мэргэжлийн хяналтын газар нь дангаар болон БОАЖГ, Цагдаагийн газартай хамтран дараах хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- *Хяналт шалгалтыг хэсэгчилсэн байдлаар хийж 12 зөрчил илрүүлэн 4 зөрчлийг Цагдаагийн байгууллагад шилжүүлэн 1,800.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан, 5,034.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг төлүүлсэн,*
- *Агнуурын амьтныг хуулиар хориглосон хугацаанд агнах, барих үйлдлийг таслан зогсоох зорилгоор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар хамтран “Хавар” нэгдсэн арга хэмжээний хяналт шалгалтыг 9 суманд хийж 41 зөрчлийг илрүүлэн зөрчлийг таслан зогсоосон байна.*

Ахуйн зориулалтаар амьтныг агнах, барих үйл ажиллагаанд хэсэгчилсэн байдлаар хяналт шалгалт хийгдсэн байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Нийцлийн аудитаар нийт **175,874.1** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **38,015.2** мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, **137,858.9** мянган төгрөгийн зөрчилд /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав / зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж байна. Үүнд:

Нэг.Төлбөрийн акт:

- Ерөө бүсийн сум дундын ойн анги нь 2018 онд үүссэн Номин-Од ХХК-иас 16,018.7 мянган төгрөг, Цант-Ажнай ХХК-иас 3,307.4 мянган төгрөг, Ар-Санжит ХХК-иас 2,593.9 мянган төгрөг зэрэг нийт **21,920.0** мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй,
- Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги нь 2019 онд Түшиг суманд мод бэлтгэсэн Мойлт нуга ХХК-иас 10,894.6 мянган төгрөг, Шинэбадрах ХХК-иас 3,678.3 мянган төгрөг, Хараа бүсийн сум дундын ойн анги нь Мандал суманд мод бэлтгэсэн Тайлжийн нуруу ХХК-иас 1,242.3 мянган төгрөгийг зэрэг нийт **15,815.2** мянган төгрөгийн ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
- Хушаат, Хүдэр сумд нь ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны зөвшөөрлийн хураамжийн **280.0** мянган төгрөгийг төлөөгүй 2 иргэнд зэрлэг гахай агнах зөвшөөрөл олгосон байна.

Хоёр. Албан шаардлага:

1. 2019 оны мод бэлтгэлийн орлогын төлөвлөгөөг нийт **109,120.9** мянган төгрөгөөр тасалсан. Үүнд:
 - Хараа бүсийн сум дундын Ойн анги 61,538.8 мянган төгрөг,
 - Бэлчир бүсийн сум дундын Ойн анги 41,794.4 мянган төгрөг,
 - Орхон бүсийн сум дундын Ойн анги 5,787.7 мянган төгрөг.
2. Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги нь ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны улсын тэмдэгтийн хураамжийг 227.4 мянган төгрөгөөр дутуу тооцсон, 177.3 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч, зарцуулсан,
3. Ерөө сум 6,225.0 мянган төгрөг, Хүдэр сум 6,089.1 мянган төгрөг зэрэг нийт **12,314.1** мянган төгрөгийн ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны улсын тэмдэгтийн хураамжийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй,
4. Баруунбүрэн сум 81.6 мянган төгрөг, Баянгол сум 18.2 мянган төгрөг, зэрэг нийт **99.8** мянган төгрөгийн ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны улсын тэмдэгтийн хураамжийг дутуу төвлөрүүлсэн,
5. Ан агнуурын орлогын төлөвлөгөөг 14,723.0 мянган төгрөгөөр тасалсан,
6. 11 сум ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны зөвшөөрөл олгохдоо нийт 1,196.4 мянган төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн ойн менежментийн төлөвлөгөөний хугацаа 2016 онд дууссан атал өнөөг хүртэл шинэчлэн боловсруулж, батлуулаагүй бөгөөд хугацаа дууссан уг төлөвлөгөөг үндэслэн 2019 онд ойгоос бэлтгэх модны саналыг боловсруулсан байна.
2. Сумдын хэрэглээний мод, түлээний хэрэгцээг тооцсон судалгаа гаргаагүй, сум дундын ой ангиуд зэргэлдээ сумдын мод бэлтгэх саналыг албан бичгээр авч нэгтгээгүй байна.
3. Сумын ИТХ-аас ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар бэлтгэх модны хэмжээг батлахдаа багаар бус бөөн дүнгээр баталсан байна.
4. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийг урьдчилан төлүүлэлгүйгээр мод бэлтгэх эрхийн бичиг олгож байгаагаас их хэмжээний авлага үүссэн байна.
5. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 7.8 хувиар тасарсан байна.
6. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого болон улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.
7. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна.
8. Ахуйн зориулалтаар агнасан, барьсан амьтны тоо хэмжээ нь агнах барихаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байна.
9. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийн хураамжийн орлогыг үндэслэлгүйгээр төлөвлөснөөс орлого 75.8 хувиар тасарсан байна.
10. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.
11. Ан амьтныг агнах, барих эрхийн бичиг, үнэт цаасны тооцоог тухай бүх хийдэггүйгээс байгаль хамгаалагчид их хэмжээний үнэт цаасны үлдэгдэлтэй байна.
12. Ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг тогтоох тухай тогтоолын хэрэгжилтэд хэсэгчилсэн байдлаар хяналт шалгалт хийгдсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

- Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, БОАЖЯ-аар батлуулж, хэрэгжүүлсний үндсэн дээр ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх хэмжээг төлөвлөж байх.
- Ойн нөөцгүй Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Шаамар сумдад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг хуваарилж, батлахгүй байх.
- Сумдын дараа онд бэлтгэх модны дээд хязгаар, 1 м3 модонд ногдох төлбөрийн хэмжээг үндэслэн орлогыг төлөвлөж байх.
- Ойгоос бэлтгэх мод, ахуйн зориулалтаар агнах, барих амьтны улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийг хуулийн дагуу мөрдөж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг дээшлүүлэх.
- Сумдын ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч байх.

Аймгийн БОАЖГ-ын дарга З.Түвшинтөгст:

- Сумдын дараа онд бэлтгэх хэрэглээний мод, түлээний тоо хэмжээний саналыг батлагдсан маягтын дагуу баталгаажуулан авч байх.
- Сумдын дараа онд бэлтгэх модны хэмжээг тооцсон дэлгэрэнгүй судалгаа, ойн нөөцгүй сумдын болон ойн сан бүхий сумдын Засаг дарга нартай дараа онд бэлтгэх модны хэмжээг харилцан тохиролцсон гэрээ, БИНХ, багийн Засаг даргын санал, мэргэжлийн ойн ангийн тооцоолол, дүгнэлт зэргийг авч, албажуулсны үндсэн дээр мэдээ тайланг нэгтгэн гаргаж байх.
- Сум дундын болон сумын ойн ангийн ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих, мэдээллийн санг бий болгож, архивлах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

- Аймгийн ИТХ-ын тогтоолыг үндэслэн дараа онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг “Ойгоос мод бэлтгэх журам”-д заасан хугацаанд багтаан батлах.
- Журамд заасны дагуу арчилгааны, цэвэрлэгээний, үйлдвэрлэлийн, ашиглалтын огтлолтоор бэлтгэх модыг ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл бүрээр батлах.
- Иргэдийн ахуйн хэрэглээний болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор бэлтгэх модыг багийн Засаг дарга болон БИНХ-ын саналыг үндэслэн баг тус бүрээр хуваарилах.

- Ойн мэргэжлийн байгууллага, ойг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн мод бэлтгэх гэрээ, ажлын тайланг хууль, журамд заасан хугацаанд хэлэлцэн, үр дүнг тооцож байх.

Сумдын Засаг дарга нарт:

- Дараа онд ойгоос бэлтгэх модны хэмжээг тооцсон дэлгэрэнгүй судалгаа, ойн нөөцгүй сумдын засаг дарга нар ойн сан бүхий сумдын засаг дарга нартай дараа онд бэлтгэх модны хэмжээг харилцан тохиролцсон гэрээ, БИНХ, багийн Засаг даргын санал, мэргэжлийн ойн ангийн тооцоолол, дүгнэлтийг хавсарган аймгийн Засаг даргад хүргүүлж байх.
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх тогтоолын хэрэгжилт, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж байх.
- Сумын болон мэргэжлийн байгууллага, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөний хугацаа дуусмагц шинэчилж, баталгаажуулах.

Сум дундын болон сумын Ойн ангийн дарга нарт:

- Сумдын байгаль хамгаалагчдын олгосон эрхийн бичгийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого, ан амьтны нөхөн төлбөрийн орлогыг төрийн сангийн мэргэжилтэн, татварын байцаагчаар баталгаажуулсан дараа тайлан мэдээг гаргаж байх.
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлсний үндсэн дээр эрхийн бичгийг олгож байх, нэгэнт үүссэн авлагыг тайлант жилд багтаан барагдуулах.
- Ойн сан бүхий Баянгол, Хушаат сумд талбай тусгаарлалтын хураамжийг журмын дагуу ногдуулж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР


С.БААСАНСҮРЭН

АУДИТОР

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Т.ОДСҮРЭН

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ


**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: (976)-7036-3653


2020.04.06 № 368
танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн ИТХ-ын “2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай”, “2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтоох тухай” тогтоолуудад хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Хариу тайлбар, саналыг хавсралтаар хүргүүлэв.

Цаашид ойн нөөцийн ашиглалт, ахуйн зориулалтаар агнах амьтны тоо хэмжээ, орлогын төлөвлөгөөг бодит нөөц, боломжинд тулгуурлан боловсруулж орлогын төлөвлөгөө, улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу тооцож бүрэн төвлөрүүлэх талаар аймаг, сумтай хамтран тодорхой ажлуудыг зохион байгуулах ба аудитын тайлангийн төсөлд оруулах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудас /

ДАРГА  З. ТҮВШИНТӨГС
43080373

alban bichig /jijig /

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2020 оны 02 сарын 16-ны өдрийн 437 тоотын Хавсралт

9057897-4315101007

Хариу тайлбар, санал

№	Өгсөн зөвлөмж	Тайлбар, санал
1	Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, БОАЖЯ-аар батлуулах	Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажил нь улсын төсвөөр 10 жил тутамд хийгдэж аймгийн Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулдаг. 2019 онд аймгийн хэмжээнд ой зохион байгуулалтын ажил хийгдсэн. БОАЖЯ-ны Ойн судалгаа, хөгжлийн төв материал боловсруулалтын ажлыг хариуцан ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөг 2021 оны 1-р улиралд боловсруулж, батлуулах төлөвтэй байгаа учир аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмжөөс хасуулах саналтай байна.
2	Ойн нөөцгүй Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Шаамар, сумдад ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг хуваарилж, батлахгүй байх	2019 оны ойн нөөц ашигласны төлбөрт орох орлогын төлөвлөгөөг сум тус бүрээр тооцож мод бэлтгэх сумын нэрийг тусгаж аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн. Энэхүү аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст болгон өөрчлүүлэх саналтай байна.
3	Сумдын дараа онд бэлтгэх модны дээд хязгаарыг 1 м ³ мод бэлтгэх төлбөр хураамжийн орлогын төлөвлөгөөг нормативт зардлаас хэтрүүлэн үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхгүй байх	Тус газрын зүгээс сумдын дараа онд бэлтгэх модны 1м ³ модны үнэлгээг Монгол улсын Засгийн газрын 2014 оны 307 дугаар тогтоолын дагуу тооцож орлогын төлөвлөгөө гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлдэг. Энэхүү аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст болгон өөрчлүүлэх саналтай байна.

Нэмэлт: Байгаль орчин, аялал жуулчлалын газраас жил бүр дараа оны орлогын төлөвлөгөөг менежментийн төлөвлөгөө, БОАЖСайдын тушаал, сумдаас ирүүлсэн саналыг үндэслэн төлөвлөж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлдэг. Гэвч манай өгсөн саналаас илүү их хэмжээний орлогын төлөвлөгөөг тодорхой эх үүсвэрийн үндэслэлгүйгээр нэмж ирүүлдэг. Үүнээс шалтгаалж орлого тасалдаж байна.

Иймд холбогдох байгууллагаас гаргаж өгсөн саналын үндсэн дээр орлогыг төлөвлөж байх тухай зөвлөмжийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст уламжилж өгнө үү.

АЙМГИЙН БОАЖГ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Ирүүлсэн санал 1:

Ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажил нь улсын төсвөөр 10 жил тутам хийгдэж аймгийн Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулдаг. 2019 он аймгийн хэмжээнд ой зохион байгуулалтын ажил хийгдсэн. БОАЖЯ-ны Ойн судалгаа, хөгжлийн төв материал боловсруулалтын ажлыг хариуцан ажиллаж байна. Сэлэнгэ аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөг 2021 оны 1-р улиралд боловсруулж, батлуулах төлөвтэй байгаа учир аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмжөөс хасуулах саналтай байна.

Тайлбар 1:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх тухай журам”-ын 2.3-т “*Аймаг, нийслэлийн Засаг дарга аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд заасан жилд бэлтгэх модны боломжит хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр, сумдын саналыг үндэслэн өөрийн аймгийн ойн сангаас дараа жилд бэлтгэх модны талаарх саналаа Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ.*” гэж заасан, өөрөөр хэлбэл ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн бэлтгэх модны төлөвлөгөөг боловсруулж, батлуулахаар зохицуулагдсан тул саналыг хүлээн авах боломжгүй болно.

Ирүүлсэн санал 2:

2019 оны ойн нөөц ашигласны төлбөрт орох орлогын төлөвлөгөөг сум тус бүрээр тооцож мод бэлтгэх сумын нэрийг тусгаж аймгийн ЗДТГ-ын СТСХ-т албан бичгээр хүргүүлсэн. Энэхүү Засаг даргад өгсөн зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т болгон өөрчлүүлэх саналтай байна.

Тайлбар 2:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу аймгийн Засаг дарга жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхээр хуульчлагдсан тул саналыг хүлээн авах боломжгүй болно.

Ирүүлсэн санал 3:

Тус газрын зүгээс сумдын дараа онд бэлтгэх 1 м3 модны үнэлгээг Монгол улсын Засгийн газрын 2014 оны 307 дугаар тогтоолын дагуу тооцож орлогын төлөвлөгөөг гаргаж аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлдэг. Энэхүү аймгийн Засаг даргад өгсөн зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т болгон өөрчлүүлэх саналтай байна.

Тайлбар 3:

Тайлбар 2-той ижил тул хүлээн авах боломжгүй болно.

СЭЛЭНГЭ БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИАС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМ ДАХЬ СЭЛЭНГЭ БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИ

Цагааннуур сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 99824311, 99505170

2020.07.08 № 33
танай 2020.07.03 -ны № 125

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай.

Танай байгууллагаас аймгийн ИТХ-ын “2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай”, “2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтоох тухай” тогтоолуудын хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан доорхи саналыг хүргүүлэв.
Үүнд:

1. Хүснэгт 3 гаргасан дүгнэлтээс Зүүнбүрэн сум 11250,0 төгрөг зөрүү 8400,0 төгрөг тасарсан харагдаж буйн тус сумын иргэд түлшний модыг Түшиг сумаас авдаг тул оруулах боломжгүй учир тухай сум ойн нөөцгүй тул АИТХ-аас өөр сумаас авах модны дээд хэмжээг нь баталдаг.

2. Тус сум дундын ойн анги нь мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ үнэт цаасыг Ой судалгаа, хөгжлийн төвөөс нэхэмжилэн авч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад түлшний, хэрэглээний мод бэлтгэх, тээвэрлэхэд олгоходоо Цагааннуур суманд ойн анги, Түшиг сум, Зүүнбүрэн суманд олгоход байгаль хамгаалагчаар олгуулдаг.

Дээрхи үнэт цаасыг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн тамга дарж баталгаажуулдаг тул 2018 оны 08 дугаар сараас 2019 оны 05 дугаар сар хүртэл өөрийн нэмэлт дансанд авч зарцуулсан иймд тэмдэгтийн хураамжыг тус сум дундын ойн ангийн тамга ашигладаг тул цаашид яаж шийдэх вэ..

3. Хүснэгт 7-т Сэлэнгэ бүсийн сумдад тусгай зөвшөөрөлтэй ойн мэргэжлийн байгууллага, ойн бүхий сандаа цэвэрлэгээний ажлаар мод бэлтгэх ойн санг гэрээгээр эзэмшдэг нөхөрлөлүүдийн үйл ажиллагааны тайланг сумдын ИТХ-аар тухай жилийн эцэст хуралдаанаар хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт гарган ажиллаж хангалттай үнэлгээ авсан нөхцөлд дараа жилд бэлтгэх модноос хуваарь олгон ажиллаж байна.

4. Түшиг суманд үйл ажиллагаа явуулж буй Мойлт нуга ХХК, Шинэбадрах ХХК-нуудад 2019 онд тус ойн ангиас мод бэлтгэх талбай тусгаарлалтыг хийж ойн нөөцийн төлбөрийг бүрэн төлүүлэн мод бэлтгэх эрхийн бичиг олгохыг байгаль хамгаалагч Ү.Отгонбаяр, Ч.Чойсүрэнжав нарт мэдэгдсэн боловч бүрэн төлүүлээгүй тухай газарт модны нөөц байхгүй байсан гэдэг шалтгааны улмаас дээрх байдал үүссэн 2019 оны эцэст тулгалт хийж 2020 оны 2 дугаар сард Шинэбадрах ХХК-ыг 3000,0 төгрөгийг Түшиг сумын төрийн санд тушаалгасан.

Иймд тус байгууллага нь цаашид Ойн тухай хууль, дүрэм, журмын дагуу бүсийн сумдад ажилдаг эрх бүхий ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд БОАЖГ, сумдын ЗДТГазартай хамтарч ажиллах, бүртгэл хөтлөн өр, авлага үүсгэхгүй ажиллах саналтай байна.

ДАРГА



Н.АМАРЖАРГАЛ

СЭЛЭНГЭ БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИАС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Ирүүлсэн санал 1:

Хүснэгт 3-т гаргасан дүгнэлтээс Зүүнбүрэн сум 11,250.0, зөрүү 8,400.0 мянган төгрөг тасарсан харагдаж буй нь тус сумын иргэд түлшний модыг Түшиг сумаас авдаг тул оруулах боломжгүй учир тухайн сум ойн нөөцгүй тул АИТХ-аас өөр сумаас авах модны хэмжээг нь баталдаг.

Тайлбар 1:

Тайлангийн Хүснэгт 3-т аймгийн БОАЖГ-ын боловсруулсан орлогын төлөвлөгөөний саналыг аймгийн ИТХ-аар сумдад хуваарилан баталсан төлбөрийн орлогын төлөвлөгөөтэй харьцуулсан бөгөөд аймгийн СТСХ, БОАЖГ-ын мэргэжилтнүүд ойн нөөцгүй Сүхбаатар, Шаамар, Сайхан, Орхон, Орхонтуул, Жавхлант, Зүүнбүрэн сумдад орлого төлөвлөн, аймгийн ИТХ-аар батлуулсан байгааг дүгнэсэн болно.

Ирүүлсэн санал 2:

Тус сум дундын ойн анги нь мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ, үнэт цаасыг Ой судалгаа, хөгжлийн төвөөс нэхэмжлэн авч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад түлшний, хэрэглээний мод бэлтгэх, тээвэрлэхэд олгохдоо Цагааннуур суманд ойн анги, Түшиг, Зүүнбүрэн суманд байгаль хамгаалагчаар олгуулдаг.

Дээрх үнэт цаасыг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангийн тамга дарж баталгаажуулдаг тул 2018 оны 08 дугаар сараас 2019 оны 05 дугаар сар хүртэл өөрийн нэмэлт дансанд авч зарцуулсан. Иймд тэмдэгтийн хураамжийг тус сум дундын ойн ангийн тамга дарж ашигладаг тул цаашид яаж шийдэх вэ?

Тайлбар 2:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийн орлого нь сумын орон нутгийн төсвийн орлого тул тэмдэгтийн хураамжийг төрийн сангийн орлогын дансанд урьдчилан төлүүлж байх шаардлагатай. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг сум дундын ойн анги нь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулах эрхгүй болно.

Ирүүлсэн санал 3:

Хүснэгт 7-д Сэлэнгэ бүсийн сумдад тусгай зөвшөөрөлтэй ойн мэргэжлийн байгууллага, ой бүхий сандаа цэвэрлэгээний ажлаар мод бэлтгэх ойн санг гэрээгээр эзэмшдэг нөхөрлөлүүдийн үйл ажиллагааны тайланг сумдын ИТХ-аар тухайн жилийн эцэст хуралдаанаар хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт гарган ажиллаж хангалттай үнэлгээ авсан нөхцөлд дараа жилд бэлтгэх модноос хуваарь олгон ажиллаж байна.

Тайлбар 3:

Аудитын явцад ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, сумын ИТХ-аар хэлэлцсэн эсэхийг нотлох баримтыг ирүүлээгүй болно. Аудитын тайлангийн төсөл хүргүүлсний дараа Цагааннуур сумын ИТХ-ын 2019 он 12 дугаар сарын 16-ны өдрийн 78-82 дугаар тогтоолуудын хуулбарыг ирүүлсэн тул тайланд засвар оруулав.

Ирүүлсэн санал 4:

Түшиг суманд үйл ажиллагаа явуулж буй Мойлт нуга ХХК, Шинэ бадрах ХХК-дад 2019 онд тус ойн ангиас мод бэлтгэх талбай тусгаарлалтыг хийж ойн нөөцийн төлбөрийг бүрэн төлүүлэн мод бэлтгэх эрхийн бичиг олгохыг байгаль хамгаалагч Ү.Отгонбаяр, Ч.Чойсүрэнжав нарт мэдэгдсэн боловч бүрэн төлүүлээгүй, тухайн газарт модны нөөц байхгүй байсан шалтгааны улмаас дээрх байдал үүссэн. 2019 оны эцэст тулгалт хийж 2020 оны 2 дугаар сард Шинэбадрах ХХК-иас 3,000.0 мянган төгрөгийг Түшиг сумын төрийн санд тушаалгасан.

Иймд тус байгууллага нь цаашид Ойн тухай хууль, дүрэм, журмын дагуу бүсийн сумдад ажилладаг эрх бүхий ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд аймгийн БОАЖГ, сумдын ЗДТГ-тай хамтарч ажиллах, бүртгэл хөтлөн өр, авлага үүсгэхгүй ажиллах саналтай байна.

Тайлбар 3:

Шинэбадрах ХХК-иас 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Түшиг сумын төрийн сангийн 100131600945 дугаар дансанд тушаасан 3,000.0 мянган төгрөгийг хасч 3,678.3 мянган төгрөг, Мойлт нуга ХХК-иас 10,894.6 мянган төгрөг зэрэг нийт **14,572.9** мянган төгрөгийн ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, тайланд засвар оруулав.


**СЭЛЭНГЭ АЙМАГ ХҮДЭР СУМЫН
“ОЙН АНГИ” ОНӨААТҮГ**
Сэлэнгэ аймаг, Хүдэр сум
Утас: 9628-1130, 9033-3309

2020.07.06 № 30
танай _____ -ны № _____ -т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТИЙН ГАЗАРТ

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын “2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай”, 2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтоох тухай” тогтоолуудын хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх тайлангийн төсөлд хүргүүлэх саналгүй байна.


ДАРГА _____ Г.ТАЙВАНБААТАР



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЕРӨӨГИЙН БҮСИЙН
СУМ ДУНДЫН ОЙН АНГИ**
Сэлэнгэ аймаг, Ерөө сум
Утас: 9603-3161


2020.07.06 № 39
танай _____ -ны № _____ -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2019 онд “Ойгоос мод бэлтгэх дээд хэмжээг батлах, ан амьтаныг ахуйн зориулалтаар барих, агнах тоо хэмжээг тогтоох тухай” тогтоолуудын хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын тогтоолын төсөлтэй уншиж танилцлаа.

Нэмэлт санал байхгүйг үүгээр мэдэгдэж байна


ДАРГА _____ Н.БАТСАЙХАН



**СЭЛЭНГЭ АЙМАГ
БЭЛЧИР БҮСИЙН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИ**
213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас: _____

2020.07.06 № 30
танай _____ -ны № _____ -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Аймгийн ИТХ-ын захиалга болон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй уншиж танилцлаа. Манай хариуцсан Шаамар сумын ойн сан нь хамгаалалтын бүсийн ой учир мод бэлтгэл хийгдэхгүй, мөн Сүхбаатар сум нь ойн сангийн нөөцгүй учир эдгээр хоёр суманд ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөө хийгдэх боломжгүй. Аймгийн ИТХ-аас баталсан цэвэрлэгээний ажлаар бэлтгэх 1000 м3 улиас модыг Алтанбулаг суманд баталсан ба тус суманд уг модны нөөц байхгүй, хуваарь үндэслэлгүй олгогдсоноос орлогын төлөвлөгөө тасалдсан болно.

Бусад дүгнэлтүүдийг хүлээн зөвшөөрч байна.


ДАРГА _____ Ж.ЭРДЭНЭЦОГ
1319090013 а. 3759895


**СЭЛЭНГЭ АЙМАГ
ХАРААГИЙН БҮСИЙН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИ**
Сэлэнгэ аймаг, Мандал сум
Утас: 70367077, 93013707

2020.07.06 № 40
танай _____ -ны № _____ -т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ:

2019 оны аудитын тайлангийн төсөлтэй уншиж танилцлаа. Манай байгууллагаас тайлангийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлт, тусгуулах санал, хүсэлт байхгүй болно.


ДАРГА _____ Р.НАРАН
4316133346 а. 3742652

СЭЛЭНГЭ АЙМАГ
БАРУУНБҮРЭН СУМАН ДАХЬ
ОРХОНЫ БҮСИЙН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИ

213200 Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум, Цагаан овоо 3-р баг
Утас: 9306-3782

2020.07.07 № 11
танай 2020.07.03-ны № 125

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР-Т

Албан шаардлагын хариу хүргүүлэх
тухай

1.Аймгийн ИТХ-ын “2019 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай”, “2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтоох тухай” тогтоолуудын хэрэгжилт сэдэвт нийцлийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийн албан шаардлагын хариуг хүргүүлж байна.

1.2019 онд мод бэлтгэлийн орлогын төлөвлөгөө тасарсан нь Аймгийн ИТХ болон сумдын ИТХ-аас баталсан хэрэглээ болон түлшний мод бэлтгэх, хуваарийн мод бэлтгэлийн гүйцэтгэл дутуу хийгдсэнээс орлогын төлөвлөгөө тасарсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөө их хэмжээгээр тасалсан сумдууд болох Орхонтуул, Хушаат сумдад батлагдсан иргэн ААН-ийн мод бэлтгэлийн төлөвлөгөө нь сумын хурлаас баталсан хуваарьт багтаан бэлтгээгүй учраас орлогын төлөвлөгөө тасарсан.

2.Улсын тэмдэгтийн хураамжийг 81.6 мянган төгрөгөөр дутуу тооцсон нь Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай хуулийн 35.5 дахь заалтыг зөрчсөн байсныг мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох албан тушаалтан нарт үүрэг даалгавар өгч тухайн зөрчлийг арилгах тал дээр ажиллаж байна.

3.Сумдын байгаль хамгаалагчдын олгосон эрхийн бичгийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг төрийн санд төвлөрүүлэн ажиллаж байна.

4.Хушаат суманд 2019 онд ойн мэргэжлийн байгууллага ажиллалагүй учраас мод бэлтгэлийн ажил хийгдээгүй болно.

ДАРГА



У.БАЯН-ЭРДЭНЭ

Хавсралт 1

Зөрчлийн утга		Ерөө бүсийн СДОА	Хүдэр сумын ойн анги	Орхон бүсийн СДОА	Бэлчир бүсийн СДОА	Хараа бүсийн СДОА	Сэлэнгэ бүсийн СДОА	БОАЖГ	ДҮН
Төлбөрийн акт	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн	21,920.0					15,815.2		37,735.2
	Ахуйн зориулалтаар агнах ан амьтны зөвшөөрлийн орлогыг төлүүлээгүй							280.0	280.0
	Актын дүн	21,920.0	-	-	-	-	15,815.2	280.0	38,015.2
Албан шаардлага	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасалсан			5,787.7	41,794.4	61,538.8			109,120.9
	Ан агнуурын зөвшөөрлийн орлогын төлөвлөгөөг тасалсан							14,723.0	14,723.0
	Улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлээгүй буюу дутуу төвлөрүүлсэн	6,225.0	6,089.1	99.8			404.7	1,196.4	14,096.1
	Албан шаардлагын дүн	6,225.0	6,089.1	5,887.5	41,794.4	61,538.8	404.7	15,919.4	137,858.9
Акт, албан шаардлагын дүн		28,145.0	6,089.1	5,887.5	41,794.4	61,538.8	16,219.9	16,199.4	175,874.1